



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 9,646,756,520.00 (есөн тэрбум зургаан зуун дөчин зургаан сая долоон зуун тавин зургаан мянга таван зуун хорь) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, эзэмшигчийг тогтоож, бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3.Энэ тогтоол гарсантай холбогдуулж 2024 оны 775 дугаар тогтоолыг хүчингүй болсон тооцсугай.

2.4.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.5.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000083  
1-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2025 оны дугаар сарын ...-ны/ний өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

| №        | Төсөл, арга хэмжээний нэр, байршил  | Төсөл, арга хэмжээний хүчин чадал  | Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)   | Улсын комиссын акт |                 | Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага   |
|----------|---|--|--|--------------------|-----------------|--|
|          |   |  |  | Огноо              | Дугаар          |  |
| 1        | Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга (Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Орил баг, өөрийн эзэмшлийн газар дээр)                           | Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, 62 ортой барилга, дунд төвөгшилтэй, зоорьгүй, 4 давхар, тэнхлэгээрээ 42.0*15.0м, (гадна цахилгааны шугам, цэвэр бохир усны, дулааны шугам, холбооны шугам, дулааны узель, хүзүүвчийн барилга) | 7,949,200,000.00   | 2024.10.29         | ББКД-82-0010/24 | Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газар, Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг               |
| 2        | Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн барилга (Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сум, Эрүүл мэндийн төвийн барилга, өөрийн эзэмшлийн газар дээр) | Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, 20 ортой, дунд төвөгшилтэй, зоорьгүй, 3 давхар, тэнхлэгээрээ 30.0м*15.0м өргөтгөлийн барилга (гадна цахилгааны КТПН, гадна цэвэр бохир усны шугам, гадна цөмөнтэн талбай)                     | 1,697,556,520.00   | 2020.11.05         | УҚД-2020/66     | Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар, Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төв |
|          |   |  | 9,646,756,520.00   |                    |                 |  |
| НИЙТ ДҮН |   |  | (есэн тэрбум зургаан зуун дөчин зургаан сая долоон зуун тавин зургаан мянга таван зуун хорь) |                    |                 |  |